

“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04 дүгээр сарын 27

№ 01

Дархан -Уул аймаг

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 14.00 цагт компанийн хурлын зааланд болов.

Хуралд:

ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ ХК нь 8.945 300 ширхэг хувьцаатайгаас хуралд хувьцаа эзэмшигч:

- 1. Намсрай овогтой Мөнхдаш - 7.109 300 ширхэг хувьцааны саналаар**
- 2. БИ ДИ СЕК ХК – 1. 314 590 ширхэг хувьцааны саналаар тус тус оролцов.**

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан **8 945300** хувьцааны саналын эрхтэй хувьцааны тоог **8.423 890** ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц **94.1 %** хувьтай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн **69.1-д** заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 14цаг 10 минутанд эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга **С.Дагиймаа** үг хэлэв.

-Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай тогтоолд хурлыг удирдах даргаар **Н.Мөнхдашийг** томилсон . Хурлын дарга ажлын боломжоос шалтгаалан хуралд биечлэн оролцох боломжгүйн улмаас хурал зохион байгуулах комиссын дарга **С.Дагиймаа- д** итгэмжлэл олгосоны дагуу миний бие өнөөдрийн хурлыг удирдаж явуулна.

-Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд та бүхэнтэй нээлттэй ярилцаж санал бодлоо хуваалцахын зэрэгцээ өнгөрсөн жилд хийсэн ажлын бүтээмж, үйл ажиллагааны болон санхүүгийн талаар дүгнэж санал бодлоо илэрхийлэх боломж олдож байгаад баяртай байна. Цаашидаа компанийхаа төлөө тавьсан зорилго зорилтоо хэрэгжүүлж ажиллах үүднээс хамтарч ажиллах, компаний ашиг орлогыг нэмэгдүүлэх алдагдалыг бууруулах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгааг нийт хуралд оролцож буй компаний эрх бүхий албан тушаалтнуудад өөрийн зүгээс байр сууриа илэрхийлэв. Ингээд хуралаа эхлэж хурлын дэгийг уншиж танилцуулая.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
- 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
- ТУЗ-ийн гишүүдийг томилох

Тус компанийн 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг менежер Ч.Золзаяа, жилийн эцсийн санхүүгийн тайланг ерөнхий нягтлан бодогч Б.Пүрэвсүрэн, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гүйцэтгэх захирал

Б. Ганпүрэв нар танилцуулах талаар төлөвлөөд байна. Зөвшөөрч байна уу. Хувьцаа эзэмшигчид зөвшөөрөв.

СОНССОН НЬ:

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2017 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг менежер Ч.Золзаяа танилцуулав. Үүнд:

- **Үйлчилгээний соёл, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр:**

1. Орон нутгийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон.
2. Аймгийн ХАҮТ, БОАЖГ-аас зохион байгуулсан зөвөлгөөнд идэвхтэй оролцсон.
3. Жил бүрийн 3-р сард УБ хотноо болдог Аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож жуулчны байгууллагатай хамтран ажиллах гэрээ хийн “HORECA EXPO -2017” Зочид буудал рестораны хангамжийн үзэсгэлэнд оролцож туршлага судлан танилцав.
4. Сар бүрийн 2,4 –р долоо хоногт ажлын байрны үзлэг хяналтыг хийж зөрчил дутагдлыг засаж ажилласан.
Registration Form-д гадаад дотоодын болон орон нутгийн жуулчдын бүртгэлийг хийн, маркетингийн судалгаа хийсэн.
5. Тэмдэглэлт баяраар хамтлаг дуучидтай хамтран ажиллаж дагалдах орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах Сар бүрийн тэмдэглэлт баярыг тохиолдуулан хамтлаг дуучидтай хамтран ажиллаж “Х Масс” хамтлаг, дуучин Хашаа, Харш хамтлаг, “MADNES хамтлаг, Дуучин Үүрийнтуяа, Саксафончин Гантулга “OUTLAW” хамтлагуудтай хамтарч Дарханыхаа залуус үйлчлүүлэгчиддээ зориулсан төрөл бүрийн бэлэгтэй арга хэмжээг зохион байгуулсан.
6. Үйлчлүүлж буй зочдын гадаад иргэдийн тоо, харьяалал зэрэг мэдээлэлийг сар бүр судалгаагаар гарган бүртгэл хийж хэвшсэн. 2017 онд Франц, Итали, АНУ, Австрали, Солонгос, Япон, Хятад, ОХУ, Швед, Норвеги гэх мэт 13-н гаруй орны 350 гаруй зочид, төлөөлөгчдөд үйлчилсэн байна.

- **Ашиг орлогоо нэмэгдүүлэх менежментийн чиглэлээр:**

Дархан –Уул аймаг дахь ОУХтөв дээр нарийн боов, пицца, түргэн хоолны “Дархан зочид буудлын” нэрийн бүтээгдэхүүн борлуулах цэг нээж ажиллуулсан.

• **Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын чиглэлээр:**

Ая дууны өргөө, караоке баар нийтийн танхим, VIP өрөөний бүх хэрэгсэлийг шинээр тохижуулсан

Рестораны их танхимд гал тогооны хэрэгсэл шинээр худалдан авч бусад тохижилт хийсэн.

Зочид буудлын зочин угтах танхимын тохижилт

Зочид буудлын нийт 66 өрөөний цонхыг вакум болгосон

Биллиард танхим шинээр тохижуулсан

Саун массажны өрөө

Ялтсан болер

Зочид буудал зоогийн газрын хангамжийн хэрэгсэл шинэчилсэн

Гадна дотно камер гэх мэт зүйлсийг шинээр болон засварлаж тохижуулсан байна.

Өдрийн хоолны хямдралтай үнийн 2 төрлийн багцийн хоол, 1-р хоол – 4 төрөл, 2-р хоол – 5 төрлөөр цэс гарган үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь зочид буудлаар удаан хугацаанд байрлаж буй тамирчид, сургалт семинараар ирж буй зочдын сэтгэлд их нийцэж байна.

Харилцагч байгууллагуудад хамтран ажиллах санал, үйлчилгээний талаарх мэдээллийг хүргүүлж хөнгөлттэй нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх гэрээ хийж ажиллав.

1.Дотоод хяналтын чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүрэн засуулж, дотоод хяналт, шалгалтын тайланг аймгийн МХГ-т хугацаанд нь хүргүүлж ажилласан.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛИЙН ТАЛААР:

Гус компанийн 2017 оны борлуулалтын орлогыг 12 сараар нь харьцуулан харуулбал:

Д/д	Сарууд	Зочид буудлын орлого /зочид буудал, буудлын буфет/	Зоогийн газрын орлого /хүлээн авалт, рестораны өдөр тутам/	Баарны орлого	Бусад орлого /түрээс, бусад/
1	1-р сар	20 524,2	29 802,3	1 535,5	2 343,6
2	2-р сар	10 648,0	22 888,7	495,3	2 592,4
3	3-р сар	7 759,0	22 181,9		2 046,5
4	4-р сар	20 934,0	22 988,4	81,4	2 753,2
5	5-р сар	13 544,8	16 320,4	2 335,7	4 569,9

6	6-р сар	7361.0	12232,4	823,3	656.7
7	7-р сар	8160.6	11695,3	794,9	6304.4
8	8-р сар	11520.0	13988,8	1402,1	2314.0
9	9-р сар	8480.1	23469,5	1972,8	1189.1
10	10-сар	10375.4	24296,3	1713,7	2046.9
11	11-сар	8694,2	34644,9	1647,3	3341.2
12	12-сар	5841,5	54622,1	1059,5	2799.2
Нийт дүн		133842,8	276898,6	11888,7	32957,1

Гүйцэтгэх захирал Б.Ганпүрэв 2018 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тайлагнав.

Үйл ажиллагааны чиглэлээр:

1. Аймаг орон нутгийнхаа БОАЖГ-с зохион байгуулагдаж буй үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж оролцох
2. Жилийн тэмдэглэлт баярын өдрүүдийг тохиолдуулан хамтран ажилладаг байгууллагуудад мэндчилгээ дэвшүүлж хамтлаг дуучдыг урьж баярын шоу болон урамшуулалт үйлчилгээг зарлах олон нийтэд суртчилах үйл ажиллагаануудыг зохион байгуулах
3. Байгууллагын нүүр номын хуудсыг тогтмол чанартай ажиллуулж үйл ажиллагаагаа байнга суртчилан гадагшаа таниулах ажлыг технологийн зохистой түвшинд хийх.
4. Байгууллагынхаа дотоод нөөц бололцоондоо тулгуурлан дээвэр засварын ажил хийгдэх төсөвт ажил байна.
5. Цаашид бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ орлого нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарч ажиллана.

Зочид буудал засвар тохижилт үйлчилгээ :

1. Зочид буудлын өрөөнүүдийн вакум цонхны сийгэлт засвар үйлчилгээг хийх
2. 4-р давхраас эхлэн далд шугамын сантехникийн засвар үйлчилгээ хийх
3. Байгууллагын дээврийн ус алдалтын асуудлыг цогцоор нь шийднэ.

4. Зочид буудлын цагаан хэрэглэлийг эргэлттэй 2 ээлж болгох, үйлчилгээний нэг удаагийн хэрэглэл хангамжийн материалыг орчин үеийн шинэлэг болгож set-ийг нэмэгдүүлж шинэчлэх

Ресторан засвар тохижилт үйлчилгээ

1. Рестораны урсгал орлого нэмэгдүүлэх зорилгоор өдрийн хоолны меню шинэчлэн нэмэгдүүлэх
2. Рестораны мах махан бүтээгдэхүүн түүхий эдийг ангилан хадгалж нөөцлөх хөргөгч хөлдөөгчийг нэмэгдүүлэх
3. Караоке баарны дууны удирдлагат тоног төхөөрөмжийг шинэчлэх рестораны тайзны дуу шумны пультыг шаардлага хангасан хэмжээнд шинэчлэх

Баг хамт олны олон нийтийн үйл ажиллагаа

1. Ажилчдын 2018 оны хөдөлмөр хамгаалалын ажлын дүрэмт хувцсыг олгох
2. Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд ажилчдыг бүрэн хамруулах
3. Халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлж ажилчдадаа витаминжуулалт хийх
4. Үйлчилгээний стандарт харилцаа хандлагын талаарх сэдэвчилсэн төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах

Санхүү мэдээ борлуулалт

1. Санхүүгийн программыг шинэчилж санхүүгийн тайлан тооцоог программаар гаргах
2. Санхүү нийгмийн даатгалын татварын тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх
3. Бараа материал түүхий эдийн үнийн судалгаа гаргаж хямд чанартай бараа бүтээгдэхүүнээр хангах
4. Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллана.

Цаашид зочид буудлын барилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх томоохон асуудлууд байна.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч нар хурлаас гаргасан бүхий л саналыг дэмжиж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй.
2. “ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн 2017 онд 32.749.135 99 төгрөгийн алдагдалтай ажилласантай холбогдуулан ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийг баталсугай.
3. 2018 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигтай ажиллах талаар идэвх санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал/ Б.Ганпүрэв /- д даалгасугай.
4. ТУЗ-ийн гишүүдийг томилх.

ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Н.Мөнхдаш
2. Б.Ганпүрэв
3. П.Алимаа
4. Б.Мягмардаш
5. Н.Пүрэвдаш
6. Д.Даянбилгүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

1. Б.Энхбаяр
2. Л.Ариунтуяа
3. Э.Мянганбаяр нарыг хараат бус гишүүнээр тус тус сонгосугай.

Хурал хэсэг завсарласаны дараа тооллогын комисс саналын хуудасыг тоолж тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Хурал 16.30 -д өндөрлөв.

Хурал удирдсан хурлын дарга:

Протокол бичсэн:



Н.Мөнхдаш

С.Дагиймаа